



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар A/124

Бор-Өндөр сум

**Зам ангийн ажилчдын түр байрлах газрын
зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн 4/ дэх заалт, Автозамын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр – Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай замын 1-р ээлжийн ПК0+000 – ПК41+500 хоорондох 41,5км авто замын ажлыг гүйцэтгэх “ТАНКШТЕЛЛЕ” ХХК /РД:5087627/ -д уг замын ажлыг дуусах хүртэлх хугацаанд Өлгий 6 дугаар багийн нутаг дэвсгэр дэх тодорхой солбилцол бүхий 6.0 га газрыг тус компанийн ажилчдыг түр байрлуулах зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Ажилчдын түр байрших газрыг зориулалтын дагуу, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зохистой ашиглаж, авто замын ажлыг дуусахад нөхөн сэргээлт хийн хүлээлгэж өгөхийг “ТАНКШТЕЛЛЕ” ХХК-д үүрэг болгосугай.


3. Ажилчдын түр байрлах газрын байршлын зураг, координатыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ

Ажилчдын түр байрлах газрын байршлын тойм зураг



Ажилчдын түр байрлах газрын
талбайн солбилцол

А/А	X	Y
1	377127.560	5125529.165
2	377316.215	5125595.566
3	377415.817	5125312.583
4	377227.161	5125246.182
Нийт талбайн хэмжээ		6.0 га